	1.10.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,101.7
	1.11.Бусад орлого	53,319.8
2	Сангийн сайд	321,643.8
	2.1.Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	321,643.8
Нийт орлого		1,651,495.0

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:



Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	1,252,775.2
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	100,102.8
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	37,328.3
	1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	27,701.4
	1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	244,114.7
	1.6.Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	118.8
	1.7.Үйл ажиллагааны урсгал зардал	19,845.9
	1.8.Хөрөнгийн зардал	25,104.8
Нийт зарлага		1,707,091.8

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

5 дугаар зүйл.”Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 400,000.0 сая төгрөгөөр баталсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



Нийгмийн даатгалын сангийн 2016 оны
төсвийн тухай хуулийн хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2016 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

/сая төгрөгөөр/

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
I.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР				5,304.8	5,304.8
1.1	I.Хөрөнгө оруулалт			1,400.0	1,400.0
	Шилжих			1,400.0	1,400.0
1.1.1	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2016	1,400.0	1,400.0
1.2	II.Их засвар			1,242.7	1,242.7
	Шинэ			1,242.7	1,242.7
1.2.1	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Дорнод, Чойбалсан сум/	2016	2016	50.0	50.0
1.2.2	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Дундговь, Мандалговь сум/	2016	2016	42.0	42.0
1.2.3	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Завхан, Улиастай сум/	2016	2016	180.8	180.8
1.2.4	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Өмнөговь, Даланзадгад сум/	2016	2016	200.0	200.0
1.2.5	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Өмнөговь, Цогтцэций сум/	2016	2016	20.5	20.5
1.2.6	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Увс, Улаангом сум/	2016	2016	188.3	188.3
1.2.7	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Орхон, Баян-Өндөр сум//	2016	2016	78.7	78.7
1.2.8	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2016	2016	301.9	301.9
1.2.9	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2016	2016	50.0	50.0
1.2.10	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2016	2016	75.5	75.5



1.2.11	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Нийгмийн даатгалын ерөнхий газар/	2016	2016	55.0	55.0
1.3	III.Тоног төхөөрөмж			2,473.3	2,473.3
	Шинэ			2,473.3	2,473.3
1.3.1	Нийгмийн даатгалын байгууллагуудын тоног төхөөрөмж /Аймаг, нийслэл/	2016	2016	845.3	845.3
1.3.2	Нийгмийн даатгалын байгууллагуудын автомашины парк шинэчлэл /Аймаг, нийслэл/	2016	2016	870.0	870.0
1.3.3	Нийгмийн даатгалын байгууллагуудын иж бүрэн компьютер, тоног төхөөрөмж /Аймаг, нийслэл/	2016	2016	650.0	650.0
1.3.4	Нийгмийн даатгалын байгууллагуудын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх кабинетын тоног төхөөрөмж /Аймаг, нийслэл/	2016	2016	108.0	108.0
1.4	IV.ТЭЗҮ, зураг төсөл			188.8	188.8
1.4.1	Нийгмийн даатгалын байгууллагуудын барилга, байгууламжийн зураг төсөл	2016	2016	188.8	188.8
II.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР				19,800.0	19,800.0
2.3	III. Тоног төхөөрөмж			19,800.0	19,800.0
	Шинэ			19,800.0	19,800.0
2.3.1	Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2016	2016	120.6	120.6
2.3.2	Эрүүл мэндийн даатгалын байгууллагын автомашин /Улаанбаатар/	2016	2016	90.0	90.0
2.3.3	Эрүүл мэндийн даатгалын байгууллагын цахим карт /Улаанбаатар/	2016	2016	19,589.4	19,589.4
НИЙТ				25,104.8	25,104.8



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Хүний хөгжил санд 2016 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, тус сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ, эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалтыг тогтоох, зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², Хүний хөгжил сангийн тухай хууль³, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2016 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР, ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ

3 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн төсөвт 2016 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 267,654.9 сая төгрөгөөр, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

¹ Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

² Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

³ Хүний хөгжил сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.



Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	267,654.9
	1.1.Гааль, татварын ерөнхий газар	257,654.9
	1.1.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	257,654.9
	1.2.Сангийн яам	10,000.0
	1.2.1.Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого	10,000.0

4 дүгээр зүйл.Хүний хөгжил сангийн төсвөөс 2016 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 221,079.4 сая төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	144,000.0
	1.1.Хүүхдийн мөнгө	144,000.0
2	Сангийн сайд	381,739.3
	2.1.Засгийн газрын бондын хүүгийн зардал	62,057.4
	2.2.Татварын орлогоос суутгаж төлөх урьдчилгаа мөнгө, зээлийн хүүгийн зардал	15,022.0
	2.3.Татварын орлогоос суутгаж төлөх урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн төлбөр	87,476.1
	2.4.Засгийн газрын бондын үндсэн төлбөрт	217,183.8
	2.5.Эрсдэлийн нөөц хөрөнгө	0.0

5 дугаар зүйл.Хүний хөгжил санд 2016 оны төсвийн жилд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг 0.0 төгрөг байхаар баталсугай.

6 дугаар зүйл.Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

6.1.шинээр гаргах болон дахин санхүүжүүлэх Засгийн газрын он дамжих үнэт цаас 171,028.5 сая төгрөг хүртэл;



6.2.урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт суутгагдсан улсын төсвийн орлогын дүнгээр улсын төсөвт өгөх өглөг үүсгэх хэмжээ 87,623.7 сая төгрөг хүртэл.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН УЛСЫН ЦАХИЛГААН ХОЛБООНЫ
БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ДҮРЭМ,
КОНВЕНЦИД ОРСОН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Мексикийн Нэгдсэн Улсын Гуадалахара хотноо 2010 оны 10 дугаар сард хуралдсан Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Бүрэн Эрхт төлөөлөгчдийн ээлжит их хурлаар хэлэлцэн баталсан “Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Үндсэн дүрэм, Конвенци”-д орсон нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦИД
НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Европын зөвлөлөөс Страсбург хотноо 1983 оны 03 дугаар сарын 21-ний өдөр баталсан Ялтан шилжүүлэх тухай конвенцид Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдэн орсугай.

2 дугаар зүйл.Энэ конвенцид нэгдэн орсонтой холбогдуулан дараах зүйлийг Европын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсүгэй:



1/Монгол Улсын хувьд “иргэн” гэсэн нэр томъёог дотоодын хууль тогтоомжид зааснаар ойлгоно;

2/Монгол Улсын дотоодын хууль тогтоомжид заасан байгууллага ялтан шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авах буюу илгээх бөгөөд тус байгууллага нь шаардлагатай тохиолдолд дипломат суваг ашиглаж болно;

3/конвенцийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “а”-д заасан журам нь Монгол Улс хэлэлцэн тохирогч бусад талуудтай харилцахад үйлчлэхгүй;

4/конвенцийн 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар ялтныг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх тохиолдолд энэ тухайгаа урьдчилан мэдэгдэх шаардлагатай;

5/ялтан шилжүүлэх тухай хүсэлт, холбогдох бичиг баримтын монгол эсхүл англи хэлнээ хөрвүүлсэн орчуулгыг хавсаргасан байх шаардлагатай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч,” гэснийг “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дунд хугацаанд төсвийн нэгдмэл байдлыг хангасан бодлого хэрэгжүүлэн улсын төсвийг алдагдалгүй байлгаж, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг ханган, улсын өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд тус тус даалгасугай:

1/санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах;

2/улсын төсөв, санхүү, мөнгөний бодлогыг эдийн засгийн бодит секторыг дэмжих, хувийн хэвшлийн идэвхжилийг сайжруулахад чиглүүлэх;

3/Монгол Улсын зээлжих зэрэглэл, эдийн засгийн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;

4/зээлийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн зуучлалын үр ашгийг нэмэгдүүлэх замаар зээлийн жилийн хүүг дунджаар 1-3 хувиар



бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Батсуурь/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
93 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2016 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь болох макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэнэ.

1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1.Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2016 оны эцэст 7 хувьд, 2017-2018 онд 5-7 хувьд тогтворжуулсны үндсэн дээр эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг ханган эдийн засаг тогтвортой өсөх нөхцөл бүрдүүлнэ.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримтална.

2.Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1.Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

2.3.Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлээр дотоод, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.



3.Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1.Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөрийн системийн шинэчлэлийг эрчимжүүлж, эрх зүйн орчныг сайжруулна.

3.2.Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.3.Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

**Гадаадын зээл тусламжийг зохицуулах
тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт
орлуулах тухай хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

**Эрчим хүчний тухай хуульд нэмэлт
оруулах тухай хуулийн төсөл
буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 99

Улаанбаатар
хот

**Аудитын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аудитын тухай хуульд нэмэлт,



өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

**“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн
ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын
хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 75 дугаар тогтоолын хавсралт буюу “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэсэн хэсэгт Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “5. Гаалийн ерөнхий газар, 6. Татварын ерөнхий газар” гэснийг “5. Гааль, татварын ерөнхий газар” гэж, мөн хэсгийн Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “7. Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэснийг “6. Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар” гэж, мөн хэсгийн 8-19 дэх заалтын дугаарыг “7-18” гэж, Засгийн газрын тохируулагч агентлаг гэсэн хэсгийн 3-10 дахь заалтын дугаарыг “2-9” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 75 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Засгийн газрын тохируулагч агентлаг гэсэн хэсэгт Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд “2. Төрийн өмчийн хороо” гэснийг хассугай.

3. Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.2} дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
101 дүгээр тогтоолын хавсралт

БҮХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (тегрөгөөр)
1	Хяналтын шатны шүүхийн Ерөнхий шүүгч	3 300 000
2	Хяналтын шатны шүүхийн шүүгч	3 200 000
3	Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	3 000 000
4	Давж заалдах шатны шүүхийн шүүгч	2 900 000
5	Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	2 800 000
6	Анхан шатны шүүхийн шүүгч	2 700 000



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолын хавсралтын 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“4.18.“Төрийн банк” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг арилжих;

4.19.“Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааг хувьчлах.”

2.Энэ тогтоолыг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүний хөгжил сангаас 2016 оны төсвийн жилд хүүхдийн мөнгө хэлбэрээр нийт 144,000.0 сая төгрөгийн хишиг, хувь олгохоор тогтоосугай.

2.Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан 1-17 дугаар бүлгийн өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд



хүүхдийн мөнгө олгох журам баталж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар/Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3.Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнд үндэслэн хүүхдийн мөнгөнд зарцуулах хөрөнгийн хэмжээ энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хэмжээнээс хэтрэх тохиолдолд шаардагдах хөрөнгийг Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тодотголд тусгуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар/Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн
7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг
эцэслэн шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Т.Лхагваа, Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн П.Баттулга, М.Мөнхжаргал, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилгогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах...” гэж



заасны “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан үзэж, эцэслэн шийдвэрлэн, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийн тухай” 83 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн П.Баттулга, М.Мөнхжаргал, Б.Төрболд, Б.Эрхэмбаяр нараас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад Монгол Улсын Их Хурал нь “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах” онцгой бүрэн эрхтэй гэжээ. Үүнийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад хуульчлахдаа Улсын Их Хурлын гишүүнд Засгийн газрын гишүүнийг огцруулах санал гаргах бүрэн эрхийг олгосон нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа болно. Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг огцруулах санаачилгыг хэдийд ч гаргаж Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх боломжтой болсон жишиг тогтсоор өдийг хүрлээ. Ийнхүү Засгийн газрын гишүүнийг огцруулах санал гаргах бүрэн эрхийг олгосон нь Засгийн газрын кабинетын зарчмаар ажиллах Үндсэн хуулийн үзэл баримтлалыг алдагдуулах шалтгаан болж байна.

Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.”, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэсэн нь Монгол Улсын Засгийн газар хамтын хариуцлага хүлээдэг кабинетын зарчмаар ажилладаг болохыг тодорхойлж байна. Засгийн газар кабинетын зарчмаар ажиллах гол агуулга нь Ерөнхий сайд дангаараа салбарын сайд нарынхаа ажлын талаар парламентын өмнө хариуцах бөгөөд Ерөнхий сайд ямар багтай ажиллахаа өөрөө шийднэ гэсэн хууль зүйн логик байна.

Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор Засгийн газрын бүрэн эрх эхэлдэг бөгөөд Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц,



бүрэлдэхүүний тухай асуудлыг Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэхээр Үндсэн хуульд заасан тул Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг огцруулах саналтай байгаа бол тэрхүү саналаа эхлээд Ерөнхий сайдад тавьж уг саналыг хүлээж аваад тухайн Засгийн газрын гишүүнийхээ асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх эсэх нь Ерөнхий сайдын бүрэн эрхийн асуудал гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэсэн нь Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүнд Засгийн газрын гишүүнийг огцруулах санаачилга гаргах бүрэн эрхийг олгоогүй, харин Улсын Их Хурлын 19 ба түүнээс дээш гишүүнд Засгийн газрыг огцруулах санаачилгыг хамтарч гаргахыг зөвшөөрчээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах...” гэсний “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.” гэжээ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлжээ. Үүнд:

“1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу Улсын Их Хурал нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадна Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг Монголбанкны Ерөнхийлөгч, Хүний эрхийн Үндэсний комисс, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн газар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүдийг томилдог тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасан “томилогддог албан тушаалтан” гэдэгт зөвхөн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн байна гэж үзэх боломжгүй.



2/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал нь дээрх байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, эдгээр байгууллагын албан тушаалтанд асуулга тавих, асуулт тавьж хариулт авах, тэдэнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж, санал дүгнэлт гаргах зэрэг хэлбэрээр хяналт тавих бөгөөд үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн дээрх албан тушаалтнуудыг огцруулах санал гаргах эрхтэй.

Энэ нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасан онцгой бүрэн эрхээ Улсын Их Хурлын гишүүний саналаар дамжуулан хэрэгжүүлэх нэг хэлбэр юм.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно. Ийнхүү томилогдсон Засгийн газрын гишүүн нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, хариуцсан салбарын үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаараа хариуцна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын бүтцийн байгууллага болох Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүд тайлангаа хэлэлцүүлж, өөрийг нь томилсон Улсын Их Хурлын хяналтад багтдаг байна.

Ийнхүү нэг талаас Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг албан тушаалаас нь огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хариуцлага тооцуулах, нөгөө талаас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг Улсын Их Хуралд гаргах боломжтой. Дээрх саналыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар огцруулах эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль



биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээр огцрох бөгөөд энэ нь Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээх хууль зүйн үндэслэл болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтын “Улсын Их Хурлаас ... томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, ... тэдгээрийг ... огцруулах ...” гэсэн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадна Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг олон байгууллагын албан тушаалтанд хамааралтай төдийгүй, “илтгэл, сонсгол хэлэлцүүлэх”, “тэдгээрийг огцруулах” гэсэн нь албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлсэн, Улсын Их Хурлын хянан шалгах эрхийг баталгаажуулсан хоорондоо уялдаа холбоотой зохицуулалт юм.

Дээр дурдсаныг үндэслэн тус заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Засгийн газраас уг маргаанд холбогдуулан дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлсэн байна.

“1. Монгол Улсын Засгийн газар гэсэн нэр томъёо, ухагдахуунд Ерөнхий сайд, гишүүд хамаарна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүд мөн.

2. Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/ нь үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалттайгаар явуулах учиртай бөгөөд бүрэн эрх нь Монгол Улсын Ерөнхий сайд томилогдсоноор эхэлж, шинэ Ерөнхий сайд томилогдсоноор дуусгавар болж байна.

Засгийн газрыг эмхлэн байгуулах болон хууль тогтоох эрх мэдлийн зүгээс буюу Улсын Их Хурлын гишүүдийн санаачилгаар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг огцруулах журмыг Үндсэн хуульд тусгайлан заасан бөгөөд хүндэтгэн үзэх болон бусад шалтгаанаар тэдгээрийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхтэй холбогдсон харилцааг Үндсэн хуулийн органик хууль болох Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлээр зохицуулж байна.



3. Огцруулах, чөлөөлөх ойлголт нь агуулгын хувьд ялгаатай. Монгол Улсын Үндсэн хууль, түүний органик хууль болох Засгийн газрын тухай хуульд Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/-ыг огцруулах болон чөлөөлөх санал гаргах нөхцөл, журмыг харилцан адилгүй байдлаар тусган хуульчилсан. Тухайлбал, тодорхой шалтгааны улмаас буюу бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл Ерөнхий сайдын, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагасын санаачилгаар, мөн түүнчлэн Ерөнхийлөгчийн саналаар тус тус огцруулах асуудлыг хэлэлцдэг.

Харин биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөлд чөлөөлж өгөх хүсэлтээ Ерөнхий сайд Улсын Их Хуралд, Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдад тус тус өргөн мэдүүлсний дараа Ерөнхий сайд, Засгийн газар гишүүдийг чөлөөлөх асуудлыг хэлэлцдэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж хуульчилсны дагуу Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 5 дугаар сарын 6-ны өдөр баталсан Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газрын гишүүн нь биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд албан тушаалаасаа чөлөөлж өгөх тухай хүсэлтээ Ерөнхий сайдад өргөн мэдүүлэхээр, мөн зүйлийн 3 дахь хэсэгт Засгийн газрын гишүүн өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний бодлогын асуудлаар Ерөнхий сайдтай, эсхүл гишүүдийн олонхтой санал зөрсөн зэргээс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Ерөнхий сайдад хэдийд ч гаргаж болохоор тус тус хуульчилсан нь Засгийн газар танхимын зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдгийг, Засгийн газрын гишүүнийг огцруулах, чөлөөлөх асуудлыг Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд гагцхүү Ерөнхий сайдын санаачилгаар шийдвэрлэх шаардлагатайг тодотгосон зохицуулалт болно.

4. Улсын Их Хурлын санаачилгаар Засгийн газрыг огцруулах тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс



доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавьсан байх шаардлагатай байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүд тул дээр дурдсан хуулийн шаардлага Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдийг огцруулах асуудлыг шийдвэрлэхэд аль алинд нь хамаарна гэж үзэж болохоор байна.

Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд буюу уг хуульд зааснаас өөр журмаар Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/-ыг огцруулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль зүйн үндэслэлгүй болно. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүний “хууль санаачлах эрх” энэ тохиолдолд мөн хуулийн Дөчин гуравдугаар зүйлээр хязгаарлагдаж байгаа болно.

5. Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын гишүүдийг чөлөөлөх огцруулах асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрх болох нь тодорхой байна.

Харин Үндсэн хуулийн органик хууль болох Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд шаардлагатай тохиолдолд өөрийн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын гишүүнийг огцруулах саналыг тухай бүр Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх хууль зүйн боломж нээлттэй юм. Энэхүү зохицуулалт нь эрх мэдлийг харилцан хамаарал, хяналт, тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх зарчимд нийцэж байгаа бөгөөд Засгийн газар чиг үүргээ парламентын хяналт дор харьцангуй хараат бусаар тогтвортой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт юм.

Монгол Улсын Үндсэн хуульд аливаа хууль, зарлиг, төрийн байгууллагын шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохих тул Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад заасан Улсын Их Хурлын гишүүн “огцруулах санал гаргах” гэснийг Засгийн газар /Ерөнхий сайд, гишүүд/-т хамаарахгүй байхаар өөрчилж, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх нь зүйтэй байна.” гэжээ.



Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 11 дүгээр дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэх хэсэгт:

“1. Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах, аливаа асуудлаар санал гаргах эрхтэй боловч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасан тул Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудал Ерөнхий сайдын эрх хэмжээнийх байхаар зохицуулжээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ...” гэсний “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байх үндэслэлтэй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.”, Дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.” гэж заасан нь Засгийн газар хамтын хариуцлага хүлээдэг, танхимын зарчмаар ажиллах ёстойг нотолж байна. Гэтэл Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудлыг Ерөнхий сайд өргөн мэдүүлэхгүйгээр, Улсын Их Хурлын гишүүний саналаар Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа нь танхимын зарчмаар ажиллах Үндсэн хуулийн үзэл баримтлалыг алдагдуулж байна.

3. Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Засгийн газрын ... бүрэлдэхүүн, түүнд ... өөрчлөлт оруулах ...” гэснийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “... Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах тухай саналаа ...” гэж дэлгэрүүлэн зохицуулсан байна.” гээд

Уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:

“1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан



тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ..." гэсний "... томилогдсон ... огцруулах ..." гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.", Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад "Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ..." гэж заасны "... томилогдсон ... огцруулах ..." гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй." гэсэн болно.

Тав. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийн тухай" 83 дугаар тогтоолд:

"1."Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад "Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах..." гэсний "... томилогдсон ... огцруулах ..." гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.", Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна." гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй." гэжээ.

Зургаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:



“Монгол Улсын Их Хурал 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдөр ... Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийг хэлэлцэн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн Улсын Их Хурлын 83 дугаар тогтоолыг баталсан бөгөөд уг тогтоолын үндэслэлийг дараах байдлаар тайлбарлан хүргүүлж байна:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: ... 6. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;” гэж заасан.

... Монгол Улсын Их Хурал нь Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхээ Улсын Их Хурлын гишүүний саналаар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд уг асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтаар дэлгэрүүлэн зохицуулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасан.

Засгийн газрын гишүүнийг томилох, огцруулах болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох асуудал нь хууль зүйн өөр өөр ойлголт учраас тухайн асуудлыг Улсын Их Хуралд өөр өөр байдлаар зохицуулсаар ирсэн. Тухайлбал, Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэх бөгөөд чухам хэдэн гишүүнтэй байхыг Ерөнхий сайдын өргөн мэдүүлсний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад зааснаар бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоож, өөрчилдөг. Энэ ч үүднээс Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг байн байн өөрчлөх нь ажил хэргийг завсардуулж, эзэнгүйдүүлж, иргэдийг чирэгдүүлж, төрийн албыг хүчгүйдүүлж, удирдлагын чадавх, үр нөлөөг бууруулдаг тул түүнийг тогтвортой байлгах зорилгоор хуулиар тогтоож, өөрчлөлтийг мөн хуулиар шийдвэрлэдэг.

Харин Ерөнхий сайдыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал хүн нэг бүрээр хэлэлцэж томилохоор зохицуулсан байдаг.

... Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг хэрэгжүүлэх арга замыг зохицуулсан, тухайн зохицуулалтыг дэлгэрүүлэн зохицуулсан зохицуулалт бөгөөд уг зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж дүгнэсэн нь улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт болон Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг өөр хоорондоо зөрчилтэй байна гэж үзэх бүрэн үндэслэлийг бий болгож байна.

Үндсэн хуулийн өөр хоорондоо зөрчилтэй гэсэн зохицуулалтыг зөвхөн хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой болно.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадна хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын буюу Монголбанкны Ерөнхийлөгч, Хүний эрхийн Үндэсний комисс, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүдийн асуудал ч хамаарч байгаа болно.

Гэтэл тухайн Цэцийн дүгнэлтээр түдгэлзүүлсэн заалт нь маш өргөн хүрээг хамарч байгаа атал Үндсэн хуулийн цэц зөвхөн Засгийн газрын үйл ажиллагааны нөхцөл байдлыг дүгнэж түдгэлзүүлж байгаа нь хэт өрөөсгөл болсон байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал нь дээрх байгууллагын тайлан мэдээлэл, илтгэл сонсох, эдгээр байгууллагын албан тушаалтанд асуулга тавих, асуулт тавьж хариулт авах, тэдэнтэй холбогдсон ажил хэрэг, ёс зүйн зөрчлийг шалгаж, санал дүгнэлт гаргах зэрэг хэлбэрээр хяналт тавих бөгөөд үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн дээрх албан тушаалтнуудыг огцруулах санал гаргах эрхтэй.



Энэ нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасан онцгой бүрэн эрхээ Улсын Их Хурлын гишүүний саналаар дамжуулан хэрэгжүүлэх нэг хэлбэр юм. Гэтэл уг онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжийг шууд үгүйсгэж, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг ойлгомжгүй болгосон байна.

Иймд Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийг хэлэлцэн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн 83 дугаар тогтоолыг баталсныг үүгээр уламжилж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2, 3; Дөчдүгээр зүйлийн 2; Дөчин нэгдүгээр зүйлийн 1; Дөчин гуравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, ажлаа Улсын Их Хурлын өмнө хариуцах, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа Ерөнхий сайдын бүрэн эрх эхэлж, дуусгавар болохтой шууд хамааралтай байх, Ерөнхий сайдын саналаар Засгийн газрыг бүрдүүлэх зэрэг зохицуулалтыг хуульчилж Монгол Улсын Засгийн газар нь танхимын зарчмаар үйл ажиллагаагаа явуулах Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тусгасан байна.

Хууль тогтоогч Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 5 дугаар зүйлд Засгийн газрын үйл ажиллагааны зарчмыг тогтоосон ба үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хамтын хариуцлага хүлээхээр заасан.

2. Үндсэн хууль болон холбогдох хуулиар баталгаажуулсан дээрх зарчмын хүрээнд, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. ...” гэж заасны дагуу Засгийн газрын бүрэлдэхүүнийг санал болгох, түүнд өөрчлөлт оруулах буюу Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын шинэ гишүүнийг томилох асуудалд Ерөнхий сайдын санал шийдвэрлэх үүрэгтэй.

Гэтэл Засгийн газрын гишүүнийг огцруулах асуудлыг Ерөнхий сайдын оролцоогүй буюу түүний саналгүйгээр Улсын Их Хурлын нэг гишүүний



саналыг үндэслэн Улсын Их Хурал шууд хэлэлцэн шийдвэрлэх боломжийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт бүрдүүлсэн байгаа нь эрх мэдэл хуваарилах болон танхимын зарчмын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг алдагдуулан, Ерөнхий сайдын бүрэн эрхэд халдаж, улмаар Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтын “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ...” гэсний “... томилогдсон ... огцруулах ...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. ...”; Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 11 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байна.

4. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийн тухай” 83 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн шийдвэрийн үндэслэлийг заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл; Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг; 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтад “Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан



тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах санал гаргах. ..." гэсний "... томилогдсон ... огцруулах ..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. ..."; Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийн тухай" 83 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Ж.АМАРСАНАА

**П.ОЧИРБАТ
Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 7.25

Индекс: 14003